



**MONGOLIA
MINISTRY OF FOREIGN AFFAIRS
AND TRADE**

K/12-722

Монгол Улсын Гадаад харилцааны яам Бүгд Найрамдах Чех Улсын Элчин сайдын яаманд хүндэтгэлээ илэрхийлэх ялдамд тус Элчин сайдын яамнаас 2012 оны 5 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн 612/2012-УБААТ тоот ноотны хариуд Дипломат, албан паспорт бүхий иргэд харилцан визгүй зорчих тухай 1992 оны хэлэлцээрт өөрчлөлт оруулах талаарх чехийн талын саналыг монголын тал хүлээн авч, 2011 оны 9 дүгээр сараас эхлэн албан паспорт эзэмшигчид харилцан визтэй зорчих болсныг үүгээр мэдэгдэх завшаан тохиолдов. Монголын тал ийнхүү өөрчлөлт оруулсан нь хоёр талын иргэдийн харилцан зорчих нөхцөлд ухралт болсонд харамсаж, цаашид энэ чиглэлээр яриа хэлэлцээ өрнүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлж байна.

Албан паспорт эзэмшигч Чех Улсын иргэдэд Монгол Улсад зорчиход визийг үнэ төлбөргүй /тэмдэгтийн хураамж, консулын үйлчилгээний хураамж, визийн наадаг хуудасны төлбөр авахгүй/ олгож эхэлсэн тул харилцан адил байх зарчмын дагуу Монгол Улсын албан паспорт бүхий иргэдэд ижил нөхцөл үйлчлэх талаар чехийн талаас хариу нотолгоо ирүүлэх хүсэлтийг үүгээр уламжилж байна.

Энэ ялдамд Монгол Улсын Гадаад харилцааны яам Бүгд Найрамдах Чех Улсын Элчин сайдын яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

**БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН
ЭЛЧИН САЙДЫН ЯАМАНД**

Улаанбаатар